



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/18

Баян-Өндөр сум

Уралдаан зохион байгуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 24 өдрийн А/98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу STEM хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр ашиглах үйл явцыг дэмжих, үндэсний хэмжээнд идэвхжүүлэх зорилгоор “Бүтээлч багачууд шилдэг арга зүй” уралдаан зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


2. Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд зохион байгуулах STEM боловсролын хэрэглэгдэхүүнийг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах чадварыг дэмжих, багш нарын шилдэг арга зүйн туршлага шалгаруулах уралдааныг чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Шүр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  О.АРИУНГЭРЭЛТ



Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны  
газрын даргын 2023 оны 04 сарын 13-ний  
өдрийн 4/18-р тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Ажлын хэсгийн ахлагч:

Л.Шүр-Эрдэнэ (Сургалтын арга зүй, судалгаа, хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд :

Б.Дашцэрэн (Статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д. Энхцэцэг (Шинжлэх ухаан, технологи, инноваци, их дээд , мэргэжлийн боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Д.Эрдэнэчимэг (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

П.Одончимэг (Бага боловсролын сургалт хариуцсан мэргэжилтэн)